

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ӨМӨЗО-Ы СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Урьхан* (БНХАУ)

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: сэтгүүл зүйн сургалт, нийгмийн институт, даяаршил, эс олон нийтжилт, сургалтын хөтөлбөр, “уруугаа харсан пирамид” бүтэц

ХХI зууныг мэдээллийн эрин гэдгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнд сэтгүүл зүй хэмээх өвөрмөц нийгмийн институт онцгой үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийн гол хандлага болох даяаршил, төвлрөл, ижилсэл, задрал буюу эс олон нийтжилттэй шууд холбоотой юм. Дээд боловсролын системд гарч бий өөрчлөлт, түүний хөгжлийн өнөөгийн чиг хандлага зөвхөн сэтгүүл зүйн төдийгүй бүх төрлийн сургалтын агуулга, арга хэлбэр, субъектийн үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлөх болсон. Үүнээс улбаалан БНХАУ-ын болон Өвөр Монголын Өөртөө Засах Орны сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал, хэтийн төлвийн талаар зарим их дээд сургуулийн сэтгүүл зүйн сургалтын төлөвлөгөөг хооронд нь харьцуулах аргаар өгүүлж, нийтлэг болон ялгаатай талыг гаргахыг зорилоо.

БНХАУ-ын сэтгүүл зүйн сургалт ХХ зууны эхэнд сэтгүүл зүйн мэргэжлээр анх нэг бүлэг оюутныг гадаад орнуудад суралцуулснаар, гадаадын сэтгүүл зүйн алдартай бүтээлүүдийг Хятадад хэвлүүлж эхэлснээр тавигдсан гэж үздэг. Хятад хэлээр гарсан анхны орчуулгын бүтээл 1903 онд хэвлэгдсэн Японы Мацумото Жунпингийн “Сэтгүүл зүй” гэх ном байсан бөгөөд бүтээлийн судалгааны хүрээ нь сонин чанар, дизайн, хэрэгцээ зэрэг ерөнхий асуудлууд байжээ. Дараа нь сурвалжлага, эссэ, мэдээний агуулга, найруулах арга зүй, рекламны асуудал, Барууны төв голч мэдээлэх арга, эссэ, мэдээ бичих удирдамж, мэдээний “уруугаа харсан пирамид” бүтэц зэрэг сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн олон асуудлын талаарх бүтээлүүд хэвлэгдэн гарч, ОНМХ-ийн ажилтнууд сэтгүүл зүйн талаар тодорхой мэдээлэл, төсөөлөлтэй болох боломж бүрдэж эхэлжээ.

1918 оны 10 дугаар сард Хятадын сэтгүүл зүйн судалгааны анхны багийг бүрдүүлж, Бээжингийн их сургуулийн дэргэд Сэтгүүл зүйн судалгааны хурлыг байгуулсан түүхтэй. Удалгүй Бээжин, Шанхайн их сургуульд Сэтгүүл зүйн тэнхим, Сэтгүүл зүйн баг байгуу-

лагдсан нь Хятадын сэтгүүл зүйн судалгааг хөгжүүлэх нэг чухал хүчин зүйл болж, Хятадын судлаачдын зохиосон сэтгүүл зүйн бүтээлүүд ар араасаа хэвлэгдэн гарчээ. Энэ үед гарсан сэтгүүл зүйн гол бүтээлүүд бол Шү бау хуангийн “Сэтгүүл зүй”, Гэ гун жэнгийн “Хятадын сонины түүх” зэрэг судалгааны ном юм. “Хятадын сонины түүх” нь Хятадын анхны системчилсэн томоохон бүтээл бөгөөд түүнийг зохиогч Гэ Гун жэнийг БНХАУ-ын сэтгүүл зүйн түүхийн судалгааг үндэслэгч гэж үздэг.

1956 онд “Ардын өдрийн сонин”-ы хороо, Шинхуа хороо, Радио хороо зэрэг байгууллагууд үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт хийсэн нь тухай цаг үеийн сэтгүүл зүйн судалгааны ажилд чухал нөлөө үзүүлсэн байна.

Хятадын цөөн тоот үндэстний их дээд сургуулиудын сэтгүүл зүйн боловсрол дунд, Өвөр Монголын Өөртөө Засах Орны сэтгүүл зүйн боловсрол гол байр эзэлдэг. Өвөр Монголын хамгийн анхны сонин “Нялх сонин” гарснаас хойш Өвөр Монголын сэтгүүл зүй нэгэнт зуу гаруй жилийг ардаа үлдээн, сэтгүүл зүйн сургалт, боловсрол нь мэдэгдэхүйц хөгжсөн байна. 1953 онд Хөх хотын Үндэстний дээд сургууль анх сэтгүүл зүйн мэргэжлийн ангиийг нээж, 1960 онд Өвөр Монголын Радио, телевизийн сургууль байгуулагдсанаар Өвөр Монголын сэтгүүл зүйн сургалтын эх суурь тавигдаж, хэвлэл мэдээллийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх эхлэл тавигджээ. 1975 онд Өвөр Монголын их сургуулийн Монгол хэл, утга зохиолын салбар сэтгүүл зүйн мэргэжлийн анги, 1986 онд БНХАУ-ын Боловсролын яаманы зөвшөөрлөөр Өвөр Монголын Их Сургуулийн Монгол, хэл утга зохиолын салбар

болон хятад хэлний утга зохиолын салбар тус тус сэтгүүл зүйн мэргэжлийн анги тус тус нээсэн байна. Мөн 1987 оноос сэтгүүл зүйн боловсон хүчнийг бакалаврын түвшинд бэлтгэж эхэлсэн юм. 2000 оноос Өвөр Монголын сэтгүүл зүйн боловсрол улам эрчимтэй хөгжиж, сэтгүүлч бэлтгэдэг ӨМИС, Хөх хотын үндэстний дээд сургууль, Өвөр Монголын радио, телевизийн сургуулиас гадна Өвөр Монголын үндэстний их сургууль, Өвөр Монголын багшийн их сургууль, Хөлөнбуйр дээд сургууль, Бугатын багшийн дээд сургууль зэрэг хэд хэдэн их дээд сургуульд ОНМХ-ийн боловсон хүчнийг бэлтгэх болжээ.

БНХАУ-ын сэтгүүлч бэлтгэгчид их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, тэдний агуулгыг БНХАУ-ын Харилцаа Холбооны Их Сургууль болон Өвөр Монголын багшийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн жишээн дээр тайлбарлая. ХХИС-ийн сэтгүүл зүйн бакалаврын түвшинд “Хятадын сэтгүүл зүйн түүх”, “Гадаадын сэтгүүл зүй”, “Сэтгүүл зүйн сурвалжлагын хэл найруулга”, “Хэвлэл мэдээллийн хэл найруулга ба дүгнэлт”, “Марксизм-Ленинизм”, “Сэтгүүлчийн ёс зүй”, “Хятадын эртний уран зохиол”, “Радио, телевизийн сэтгүүл зүй”, “Олон нийтийн харилцаа”, “ОНМХ-ийн менежмент”, “Зар сурталчилгаа ба олон нийтийн харилцаа”, “Ярилцлагахйх арга зүй” зэрэг мэргэжлийн хичээлүүд¹ ордог. Харин ӨМБИС-ийн сэтгүүл зүйн бакалаврын түвшинд “Монгол бичгийн товч түүх”, “Интернет сэтгүүл зүй”, “Шинэ хэвлэл мэдээлэл”, “Үндэстний онол, үндэстний бодлого”, “Монгол хэлний авиа зүй”, “Хянан найруулах арга зүй”, “Монголын уран зохиолын сонгодог бүтээлүүд”, “Үндэстний кино, телевизийн шүүмж”, “Сонины нийтлэ-

лийн шүүмж”, “Хэвлэл мэдээллийн менежмент”, “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тойм”, “Мэдээний орчуулга”, “Нэвтрүүлэг хөтлөгчийн дадлага”, “Монголын уран зохиол”, “Хятадын уран зохиолын сонгодог бүтээлүүд” зэрэг хичээлүүдийг² үздэг байна. Аль аль нь дээрх хичээлүүдийг 138-140 багц цагийн хэмжээнд судалсан байх шаардлагатай.

Харилцаа Холбооны Их Сургууль нь радио, телевизийн системийг үндэслэн хэвлэл мэдээллийн салбарт тулгуурлан, бүхэлдээ нийгэмд нээлттэй байж, өөрийн гэсэн онцлог шинжүүдийг аажмаар бий болгон, радио, телевизийг нягт хослуулан, олон түвшний, олон стандарттай, төрөлжсөн, нээлттэй сургуулийн онц-логтой сургалт явуулж, олон талт зохицол, хөндлөн нэвтрэлт, субъектийн шинж чанаруудын цогц давуу талуудыг бүрэн тусгасан байх, мөн оюутнуудын цогц чанар, мэргэжлийн ёс зүйг хөгжүүлэх, онол, практикийг хослуулах, мэдлэг, сургалтын чадварыг боловс-ролын шинж чанаруудтай хослуулах зэрэгт анхаарлаа хандуулж, мэдээ, харилцаа холбооны хүрээлэнгийн хайгуулын болон дадлага туршлагын үеэр, авьяас сургалтын загварын үзэл санааны онцлог, өвөрмөц шинж чанар бүхий өвөрмөц сургууль, аажим аажмаар өөрийн боловсруулсан боловсролын философийг бий болгон, XXI зуунд үндэсний хэмжээний, олон улсын нэр хүндтэй мэдээллийн харилцааны сургалт бүтээн байгуулахаар чармайдаг байна.

БНХАУ-ын Харилцаа Холбооны Их Сургуулийн сэтгүүл зүйн магистрын түвшинд “Улс төрийн олон нийтийн харилцаа”, “Хятад ба гадаад мэдээ”, “Сэтгүүл зүйн онол”, “Мэдээний онол”,

“Сэтгүүл зүйн онол ба практик”, “Социологи”, “Практик сэтгүүл зүй” зэрэг хичээлийг судалдаг бол ӨМБИС-ийн сэтгүүл зүйн магистрын түвшинд “Монголын мэдээллийн харилцааны түүх”, “Орчин үеийн мэдээ”, “Мэдээллийн харилцааны онол”, “Олон улсын харилцааны соёл”, “Мэдээлэл харилцааны бизнес”, “Хэвлэл мэдээллийн менежмент”, “Шинэ хэвлэл мэдээлэл судлал”, “Монголын хөгжлийн түүх”, “Мэргэжлийн англи хэл” зэрэг хичээлийг нийт 34-40 багц цагийн хэмжээнд сонгон сурсан байх ёстой юм.

Судалгаагаас үзэхэд Хятад болон Өвөр Монголын сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрүүд нь нэг яамнаас баталсан ерөнхий удирдамжийг иш үндэс болгодог учраас нэр, агуулгын хувьд ойроцоо байгаа нь ажиглагддаг. Ёс заншил, шашин суртахуун зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан цөөн тоот үндэстэн, өөртөө засах орнуудын их дээд сургуулийн заах арга нь өөрийн гэсэн онцлогтой, өвөрмөц шинж чанарыг хадгалсан байдаг. Сэтгүүл зүйн сургалт нь ч тийм байгааг бидний дээр дурдсан хичээлүүдээс харж болно.

Гэхдээ тус орны сэтгүүл зүйн сургалтанд цаашид шийдвэрлэх шаардлагатай багагүй асуудал бий. Төгсөгчдийн мэдлэгийн хүрээ явцуу, хичээлийн зохион байгуулалт болон бүтэц, агуулга тааруу, сургууль болгон өөрийнхөө бодлогод тохируулан оюутныг зааж сургана гэдэг зорилгод захирагддаг нь оюутнуудын мэдлэг, чадварт тодорхой нөлөө үзүүлдэг байна. Сургалтын хөтөлбөрт онолын хичээлүүд голлож, практик талын хичээлүүд дутмаг байгаа нь практик дадал, чадвар шаарддаг сэтгүүл зүйн мэргэжилд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнээс шалтгаалан нэгдүгээрт, оюут-

нуудын онолын мэдлэг сайн боловч хэвлэл мэдээллийн редакцид очоод шууд ажиллах практик дадал чадвар тааруу учраас ажлын байранд сэтгүүл зүйн оюутнуудын сайн талыг илрүүлэх боломжгүй. Хоёрдугаарт, сэтгүүл зүйн оюутнуудын мэргэжлийн мэдлэг нь тааруу байгаа нь ажилд орсны дараа сэтгүүл зүйн бүтээлийн чанарт сөрөг нөлөө үзүүлж, сонгож авсан сэдвийг олон талаас нь гүнзгий судлах чадваргүй юм. Энэ бүхэн нь сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр дэх онол, практикийн хичээлүүдийн тэнцвэрт харьцаа алдагдсанаас болж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна.

Оюутнуудын боловсрол эзэмшсэн мэдлэг, чадвар, тухайн үеийн сэтгүүл зүйн шаардлагад нийцэх зэрэг нь эрдэм мэдлэгийг түгээж буй багшаасаа шалтгаалах нь тодорхой.Товчоор хэлбэл их, дээд сургуулиудын багш нарын боловсролын түвшин маш өндөр, олонх нь мастер, доктор байх шаардлагатай юм. Үүнээс гадна зайлшгүй анхаарах цөөнгүй асуудал байгаагийн заримаас нь дурдвал:

- Сургуулиас сургалтын хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөөг хийхдээ онол голлож, багш нарын цалин хангамж нь заах хичээлийн цагтай холбоотой учраас ихэнх багш судалгааны болон хичээл заах аргаа онол дээрээ сууриулж, практикаа орхисон байна.
- Багшнарын хамт олончадвартай байж, олонх нь сургууль төгсмөгц багшлан, үргэлж сургуулийн хүрээнд байснаар нийгмийн болон хэвлэл мэдээллийн ажлын туршлага дутмагаас болж заан сургах явцад мэдэхгүй, чадахгүй зүйл олон гардаг байна.

Дүгнэлт

Хятадын болон Өвөр Монголын тухайн газрын төрийн бодлого,шашин суртахуун, ёс заншлаас хамааран өөр өөрийн гэсэн онцлог бүхий сургалт явуулдаг. Үүний зэрэгцээсэтгүүл зүйн сургуулиудын өмнө сургалтын материаллаг баазаа сайжруулах, сэтгүүл зүйн багш нарын мэдлэгийг дээшлүүлэх, практик давамгайлсан сургалтыг хэрэгжүүлэх, элсэгчдийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зэрэг асуудал тулгарч байна. Сэтгүүл зүйн сургалтыг сайжруулж, сэтгүүлч боловсон хүчнийг чанартай бэлтгэхэд дээрэх асуудал чухал үүрэгтэй байхын хамт тухайн мэргэжлийн онцлогоос шалтгаалан, дараах асуудалыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна. Өөр нэг онцлон хэлэх зүйл бол Өвөр Монголд онол, практикийн ач холбогдолтой гарын авалга болохуйц судалгааны бие даасан тусгай бүтээл маш ховор байна.

- Элсэгчдийн чадварыг сайжруулахын тулд мэргэжлийн өндөр ур чадвар, авьяас шаарддаг сэтгүүлч зэрэг мэргэжлээрэлсэгчдээс сургуулиуд ур чадварын давхар шалгалт авдаг болгох
- Мөн ур чадварын шалгалтыг сургуулиуд өөрсдийн онцлогт тохируулан агуулга, хэлбэр, бүтцийн хувьд өөрчлөх
- Сэтгүүлчдийг хос мэргэжлээр бэлдэх
- Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, багшлах боловсон хүчнийг оюутны ширээнээс эхлэн тусгай хөтөлбөрөөр бэлдэх
- Сэтгүүлч бэлтгэх их дээд сургуулиуд хоорондоо хамтран ажиллаж,

хоорондоо харилцан холбоотой байх

- Оюутнуудыг багаас нь сэтгүүл зүйн судалгаанд татан оруулж, энэ нь судалгаа хийх арга барилыг эзэмшүүлж, танин мэдхүйн хүрээг хөгжүүлэхийн хамт ОНМХ-ийн сул болон давуу талыг сайн мэдэх, бичиг чадварыг сайжруулах, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно.
- Сэтгүүлч мэргэжлээр төгссөн оюутнуудын өөрсдөө хийх, бүтээх оролдолгуудыг дэмжин, оюутан уран бүтээлч байх орчиныг бүрдүүлж өгөхөд сургуулиуд онцгой анхаарах шаардлагатай юм.

Сэтгүүл зүйн мэргэжил бол хувь хүнээс багагүй хүчхөдөлмөр, цаг хугацаа шаарддаг, олон мэргэжлийн зааг дээр оршдог өвөрмөц мэргэжил юм. Бидний дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд уйгагүй эрэл хайгуул хийх, онол, практик, арга зүйн мэдлэг, дадал чадвар эзэмших, тодорхой тушлага хуримтлуулсан байх шаардлагатай. Энэ бүхэн өнөөгийн сэтгүүл зүйн сургалтын өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам юм.

Ишлэл

¹ <http://xueshu.baidu.com/>

²<http://www.zhuoyuekaoyan.com/xuekejieshao/3520.html>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2017. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть VIII. Сэтгүүлчийн мэргэжил: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
2. Зулькафиль М., Норовсүрэн Л. 2011. Сэтгүүл зүйн тэнхим-50 жил. УБ.
3. Зулькафиль М. 2013. Даяаршлын үеийн дээд боловсрол ба сэтгүүл зүйн сургалт // "Сэтгүүл зүй". МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №14 (393)
4. Норовсүрэн Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ.
5. <http://xueshu.baidu.com/>
6. <http://www.zhuoyuekaoyan.com/xuekejieshao/3520>

Резюме

Статья посвящена одному из актуальных вопросов современной журналистики - вопросу подготовки творческих работников СМИ. Автор анализируя учебные программы Педагогического университета Внутренней Монголии и Университета массовой коммуникации Г.Пекин показывает положительные и негативные стороны этих программ и предлагает некоторые практические рекомендации об устранении недостатков и улучшении работы подготовки будущих журналистов СМИ Внутренней Монголии КНР.